МОНГОЛ УЛСЫН
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/169 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Их сургуулийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.14, 4.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Дотоод хэргийн их сургуулийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг жил бүр төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Дэд захирал (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат)-д, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг бүрэлдэхүүн болон харьяа сургууль, институтийн захирал, бүтцийн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийн санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулж, зардлыг зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга (цагдаагийн хурандаа Ч.Лхагважав)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (хурандаа Д.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР
БРИГАДЫН ГЕНЕРАЛ П.БАТБААТАР

13301064

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2025 оны 04 сарын 08 -ны өдрийн А/169 дугаар тушаалын хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрх зүйн үндэслэл

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/145 дугаар тушаалаар батлсан Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, Их сургуулийн захирлын Их сургуулийн үйл ажиллагааны журам, төрийн албан хаагчтай холбоотой бусад хууль тогтоомж, эрхийн акт нь энэ хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2.Хамрах хүрээ

Хөтөлбөрт тус Их сургуулийн албан хаагч, ажилтан хамрагдана.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Зорилго:

2.1.1.Ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтуудыг хэрэгжүүлсний үндсэн дээр албан хаагч, ажилтан нь сэтгэл ханамжийн баталгаатай байх, үр бүтээлтэй, идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

2.1.2.Дотоод хэргийн их сургууль (цаашид “Их сургууль” гэх)-ийн албан хаагчдын албан тушаалын болон ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс нийгмийн баталгааг нь хууль тогтоомжийн хүрээнд хангахад баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

2.2.Зорилт:

2.2.1.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох.

2.2.2.Төрийн албаны болон бусад хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1.Албан хаагч, ажилтан нэг бүрийг хамруулах;

3.2.Ил тод, нээлттэй байх;

3.3.Бодитой байх;

3.4.Дотоод нөөц бололцоонд тулгуурлах;

Дөрөв.Хөтөлбөрийн үндсэн чиглэл

4.1.Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны

тасралтгүй байдлыг хангах чиглэлээр:

4.1.1.Их сургуулийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг (2025-2028)”-ийн хэрэгжилтийг хангах;

4.1.2.Албан хаагч, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг бодитой дүгнэж, урамшууллыг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан хагас, бүтэн жилээр олгох.

4.2.Их сургуулийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

4.2.1.Албан хаагч, ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасан баталгаагаар хангах;

4.2.2.Албан хаагч, ажилтан нь Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэгийг авах;

4.2.3.Төрийн албаны тухай хуулийн хүрээнд албан хаагч, ажилтанд тусламж, дэмжлэг, үйлчилгээ, хүндэтгэл үзүүлэх журмыг хэрэгжүүлэх;

4.2.4.“Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хаагчдад орон сууцны дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нийтлэг журам”-ын хүрээнд албан хаагч, ажилтанд дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх;

4.2.5.Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагч, ажилтны цалингийн шатлал, хугацааны нэмэгдэл, мэргэжил, мэргэшлийн, болон бусад нэмэгдлийг тухай бүр шинэчлэн олгох;

4.2.6.Их сургуулийн албан хаагч, ажилтанд бүх төрлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.7.Дотоод нөөц, боломжид (хуримтлал, зээл, тусламжаар) тулгуурлан албан хаагчийн зуслангийн орон сууцыг барих ажлыг зохион байгуулах;

4.2.8.Албан хаагч, ажилтны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгох орчин нөхцөлийг нэмэгдүүлэх;

4.2.9.Хууль тогтоомжтой нийцүүлэн Их сургуулийн албан хаагч, ажилтныг шагнаж урамшуулах журмыг хэрэгжүүлэх;

4.2.10.Албан хаагч, ажилтны суралцах нөхцөл бололцоог хангах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулсан хэрэгжүүлэх;

4.2.11.Өрх толгойлсон, амьжиргааны түвшин доогуур болон гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч, ажилтны судалгааг тогтмол гарган хууль тогтоомжид заасны дагуу дэмжлэг, тусламж үзүүлэх;

4.2.12.Хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн эрүүл мэндийн, нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож олгох;

4.2.13.Албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн хүндээр өвдсөн, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, албан хаагчийн хүсэлтийг харгалзан хамт олны сайн дурын үндсэн дээр хандивын арга хэмжээ зохион байгуулах, буцалтгүй тусламжийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх;

4.2.14.Албан хаагч, ажилтны нийгмийн асуудалд тулгуурласан суурь судалгаа, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй албан хаагчдын судалгааг гаргаж түүнд чиглэсэн арга хэмжээг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

4.2.15.Төрийн цэргийн болон, хууль сахиулах байгууллага, төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын албан хаагч, ажилтны нийгмийн баталгаатай дүйцүүлэх;

4.2.16.Их сургуулийн хилийн цэргийн цол хэрэглэж буй албан хаагчийн алба хаасан хугацааг нэмэгдэлтэй тооцох асуудлыг шийдвэрлүүлэх;

4.2.17.Сайжруулсан хатуу түлшний хэрэгцээ бүхий журмын шаардлага хангасан албан хаагч, ажилтанд тусламж үзүүлэх;

4.2.18.Алба хаагч, ажилтанд зориулсан ипотекийн хөнгөлөлт, зээлд хамруулах бодлого хэрэгжүүлэх;

4.2.19.Албан хаагч, ажилтны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх, Их сургуулийн байрлалд хүүхдэд ээлтэй орчин бүхий өрөө тасалгаа, танхимтай болох.

4.3.Их сургуулийн албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг хангах чиглэлээр:

4.3.1.Албан хаагч, ажилтны ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.3.2.Албан хаагч, ажилтанд эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан албаны дүрэмт болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр цаг тухай бүр хангах;

4.3.3.Оффисын зориулалт бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулж, программ хангамжийг хөгжүүлж, цахим орчныг бүрдүүлэн аюулгүй байдлыг хангах;

4.3.4.Сургалт, судалгааны лаборатори, кабинетыг чиглэл бүрээр өргөтгөх, шинээр байгуулах, техник хэрэгслийн хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, шинэчлэх;

4.3.5.Албан хаагч, ажилтнуудад унаа, хоолны мөнгөний зохих хэсгийг тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай уялдуулан тогтоож, сар бүр олгох;

4.3.6.Их сургуулийн хотхон орчмын гадна тохижилт, аюулгүй байдлыг сайжруулж, цэцэрлэгжүүлэх, албан хаагчдын өрөө тасалгааг цэцэгжүүлэх;

4.3.7.Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх;

4.3.8.Их сургуулийн байрлалд байгальд ээлтэй ногоон орчныг бүрдүүлэх;

4.3.9.Ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлэх, ажил, амралтын зохицуулалт хийх.

4.4.Албан хаагч, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, биө бялдрыг хөгжүүлэх чиглэлээр:

4.4.1.Албан хаагч, ажилтныг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах;

4.4.2.Хамтран ажилладаг агентлаг, байгууллагуудын амралт, сувилалд албан хаагч, ажилтан болон түүний гэр бүлийн гишүүдийг амраах арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.4.3.Албан хаагч, ажилтны амралт, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэхэд анхаарч спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, бялдаржуулах, чийрэгжүүлэх, алжаал тайлах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг өрөө, тасалгааг тохижуулж, байнгын үйл ажиллагаатай болгох;

4.4.4.Алба хаагч, ажилтнуудад хөнгөлөлттэй үнээр, чанартай хоолоор үйлчилж эрүүл амьдралын хэв маяг, эрүүл хооллолт, хөдөлгөөний дутагдал, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зохистой хэрэглээний талаар сургалт зохион

байгуулах;

4.4.5.Албан хаагч, ажилтныг эрүүл мэндийн эрт илрүүлгийн багц шинжилгээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах;

4.4.6.Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих, хамгаалах;

4.4.7.Эрүүл ажлын байрыг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж, ажиллах орчны нөхцөлийг сайжруулах;

4.4.8.Гүнжийн хоолой дахь амрах байрөнд албан хаагчийг хөнгөлттэй үнээр амраах.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1.Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

5.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Зургаа.Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1.Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр харьяа, бүрэлдэхүүн сургууль, институт, бүтцийн нэгжээс санал авч боловсруулж төсвийн шууд захирагчаар батлуулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

6.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Их сургуулийн хэмжээнд нэгтгэн, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж үнэлгээ хийж, дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнана.

Долоо.Хөтөлбөрийн үр дүн

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр их сургуулийн албан хаагч, ажилтны эрүүл, аюулгүй орчинд үр дүнтэй, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөл сайжирч, нийгмийн баталгаа, төрийн албаны тасралтгүй, тогтвортой байх зарчим хангагдана.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ